



Р.УУГАНБАЯР
ХСИС-ийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн Харуул
хамгаалалтын тэнхимийн
багш, хууль зүйн
магистр, ахмад

ХУЯГЛАН ХҮРГЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ

Хураангуй

Ялтныг хуяглан хүргэх ажиллагааны тухай ойлголт, төрөл хуяглан хүргэх ажиллагааны харуул хамгаалалтын зохион байгуулалтын онцлогийн талаар судлаачийн байр суурийг илэрхийлсэн.

Түлхүүр үгс

Хорих анги, цагдан хорих төв, нэгдсэн эмнэлэг, ялтныг хорих ангид хуваарилах, хуяглан хүргэлтийн тээврийн хэрэгсэл, ялтан, хуяглан хүргэх, нүүлгэн шилжүүлэх

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар хорих байгууллага нь хорих ялыг албадан эдлүүлэх, ялтны аюулгүй байдлыг хангаж, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, ялтаас нийгэм иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх зэрэг бусад арга хэмжээг зохион байгуулах тусгай чиг үүрэгтэй төрийн байгууллага мөн.

Нөгөө талаас энэхүү чиг үүрэг нь эрүүгийн хариуцлагын зорилго /иргэн, нийгмийг гэмт

халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх\-ээс урган гарсан хэмээн үзэж болно.

Хуяглан хүргэх ажиллагааны талаар судлахын өмнө хуяглан хүргэх ажиллагаа гэж юуг ойлгох тухай хэл зүйн тайлбар болон хууль зүйн салбарын эрдэмтэн судлаачийн байр суурь, үзэл хандлагыг харьцуулан судалж тодорхой ойлголттой болох нь зүйтэй. Хуяглан хүргэх ажиллагаа гэдэг нь хуяглахаас үүсэлтэй хоршоо үг юм.

Хуяглах 1. ялт хүнийг сахиж сэргийлэх¹, 2. Хуяг дуулгаа өмсөх -Хүмүүс дандаа зэр зэвсэгтэй яван орон гэрээ орхин алс холд одохуйд биеэ хуяглаж, төмөр дуулганд толгойгоо нууж явдаг байжээ, 3. Зарим амьтны, биеийнхээ гадуур хуяг мэт юмтай болох: гахай хуяглах (нэгдүгээр сарын сүүлчээр, бодон гахай орооныхоо үед мэгж эрж, их явснаас халууцаж, харз усанд орж сэрүүцэн, хайрган дээр хэвтэж, бүх бие нь элс шороогоор өвч хучигдах), 4. Зарим юманд ган, болд мэтээр бэхлээс хийх.

Хүргэх 1. Хүрэлцэх гар хүрэх (алив юмыг гараар хүрэлцэх, барих хөдөлгөх), 2. Илгээх, явуулах, өгөх: бичиг хүргэх, бэлэг хүргэх, захидал хүргэх, хүргэж өгөх² гэсэн утгыг илэрхийлнэ.

¹ Цэвэл.Я “Монгол хэлний товч тайлбар толь”.УБ., 1966.741 дэх тал

² Цэвэл.Я “Монгол хэлний товч тайлбар толь”.УБ., 1966. 747 дах тал

Академич С.Нарангэрэл /Sc.D/ өөрийн бүтээлдээ: хуяглан хүргэх ажиллагаа гэдэг нь баривчлагдагч, ялтан буюу цэргийн олзлогдогчийг товлосон газарт харгалзуулан хүргэх зэвсэглэсэн хамгаалалт³ гэж тодорхойлсон бол Б.Нямгомбо, Ч.Хүрэлбаатар нар өөрийн бүтээлдээ: Ялтанг цагдан хорих байр, хорих анги хооронд шилжүүлэх, тусгаарлах тасалгаа, сахилгын байрнаас гаргаж тодорхой объектод хүргэх, буцаах үед тодорхой журам, зааврыг баримтлан аюулгүй байдлыг хангаж тээврийн хэрэгсэл болон явганаар гүйцэтгэж буй харуул хамгаалалтын ажиллагааг ойлгоно⁴ гэж тус тус тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл хуяглан хүргэх ажиллагаа нь нэг хорих ангийн байршлаас нөгөө хорих ангийн байршилд харуул хамгаалалтын хяналтан дор ялтан хоигдогчийг зөөвөрлөх ажиллагаа гэж ойлгож болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2016 оны 04 сарын 28-ны өдөр баталсан хуяглан хүргэлтийн зааварт Хуяглан хүргэх ажиллагаа гэж ялтныг ял эдлэх хорих анги, гянданд хуяглан хүргэх, хорих анги хооронд болон 401 дүгээр хорих анги-Нэгдсэн эмнэлэгт шилжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагад ажиллуулах, хорих анги, нэгжийг нүүлгэн шилжүүлэх, түүнчлэн хорих ангийн хамгаалалтын бүсэд харуул

хамгаалалтын хяналтанд явганаар үйлдэгдэж буй ажиллагааг ойлгоно⁵ гэж тодорхойлсон байна.

Дээрхээс үзвэл хуяглан хүргэх ажиллагааны талаар эрдэмтэн судлаачид нэгдсэн ойлголтонд хүрээгүй бөгөөд энэ нь онолын хувьд маргаантай асуудлуудын нэг болох нь тодорхой харагдаж байна.

Дэлхийн жишгээс хархад хуяглан хүргэх хамгаалалтын ажиллагааг Зэвсэгт хүчний, Хууль сахиулах байгууллагын хуяглан хүргэлт, онцгой ачаа тээшийн хуяглан хүргэлт⁶ гэж гурав ангилж авч үздэг бол манай улсын хувьд ялтныг хуяглан хүргэх ажиллагаа нь хуяглан хүргэх, нүүлгэн шилжүүлэх гэсэн хоёр төрөлтэй.

Хуяглан хүргэлтийн ажиллагааг хэлбэрийн хувьд тээврийн хэрэгслээр болон явганаар хуяглан хүргэх гэж 2 ангилж болно.⁷ Хуяглан хүргэх ажиллагааг орон нутаг, газар зүйн байршлаас шалтгаалан нисэх онгоц, суудлын галт тэргээр зохион байгуулж болох ба энэ тохиолдолд харуул хамгаалалтын ажилтныг ялтны тооноос хамааран хорих анги, албаны дарга, Цагдан хорих төвийн Хуяглан хүргэлтийн хэлтсийн дарга томилж, үүргээр хангах ба Засгийн газрын 2007 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэний

⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн н/07 дугаар тушаалаар батлагдсан “Хуяглан хүргэх ажлын заавар”-ын 1.3 дах заалт

⁶ <https://ru.wikipedia.org/wiki/>

⁷ Нямгомбо.Б, Хүрэлбаатар.Ч “Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаа”.УБ.,2013./х/.157

³ Нарангэрэл.С “Эрх зүйн эх толь бичиг” нэмж засварласан III дах хэвлэл.УБ.,2011./х/.571

⁴ Нямгомбо.Б, Хүрэлбаатар.Ч “Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаа”.УБ.,2013./х/.156

нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-т заагдсан арга хэмжээг авна.⁸

Хуяглан хүргэх ажиллагааны харуул хамгаалалтын онцлог, ажилтны гүйцэтгэх үүрэг:

Хуяглан хүргэлтийн офицер нь батлагдсан нэрс, хувийн хэрэгтэй ялтныг тулган хүлээн авч, түүний бие болон эд зүйлд үзлэг, нэгжлэг хийн холбогдох хууль, дотоод журмаар зөвшөөрөгдсөнөөс бусад эд зүйлийг хураан авч, хуяглан хүргэх ажиллагааны явцад биеэ хэрхэн авч явах талаар танилцуулан, тээврийн хэрэгсэлд суулгах ажиллагааг биечлэн зохион байгуулна.⁹

Хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулах алба, анги нь

➤ Хуяглан хүргэх ажиллагаанд явах машин техникийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах

➤ Хуяглан хүргэх ажиллагаанд явах алба хаагчдын бэлтгэл сургуулилалт хийх нөхцөлөөр хангаж, тусгай хувцас, галт зэвсэг, тусгай хэрэгсэл шаардлагатай бол албаны нохойгоор хангах үүрэг хүлээх бөгөөд хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулах ажилтнууд дараах зарчмыг мөрдлөг болгон ажиллана. Үүнд:

➤ Тогтоол гүйцэтгэх газар, хорих анги, албаны даргын баталсан

нэрсийн жагсаалтаас зөвшөөрөлгүй ялтныг авч үлдэх, тээвэрлэх

➤ Хуяглан хүргэж байгаа ажиллагааны нууц задхуулах, ялтныг төрөл садан, бусад хүнтэй уулзуулах

➤ Хуяглан хүргэх замд зөвшөөрөгдөөгүй газарт зогсох, ялтныг буулгах, гадны хүн тээвэрлэх

➤ Ялтныг хуяглан хүргэх ажиллагаанд зориулалтын бус, тэдгээрийн ар гэрийн болон хувийн авто машин ашиглах

➤ Батлагдсан маршрут зөрчих, бүрэн бус техникээр ялтныг тээвэрлэх, даац хэтрүүлэх

➤ Хуяглан хүргэх ажиллагааг гүйцэтгэх үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэхгүй байх эдгээр зарчмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах шаардлагатай.

Энэ зарчим нь хуяглан хүргэх ажиллагааг гүйцэтгэж буй бүх албан хаагчдад чанд мөрдөх шаардлагатай бөгөөд өдөр тутам харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх ажилтнаас дараах мэдлэг, чадварыг заавал илүү эзэмшсэн байх шаардлагатай. Үүнд:

➤ Хуяглан хүргэх ажиллагааны үед гаднаас халдан довтлох үед аюулгүй байдлаа хэрхэн хангах

➤ Гэнэтийн осол, аваар, техникийн гэмтэл гарсан үед хуяглан хүргэгдэж буй ялтануудын хамгаалалтыг хэрхэн зохион байгуулах

➤ Хуяглан хүргэх явцад ялтны эрүүл мэнд муудсан тохиолдолд хэрхэх, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх чадвартай байх

⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2016 оны 04 дугаар сарын 28-ний өдрийн н/07 дугаар тушаалаар батлагдсан “Ялтныг хуяглан ажлын хүргэх” зааварын 2.17 дэх заалт

⁹ Нямгомбо.Б, Хүрэлбаатар.Ч “Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаа”.УБ.,2013./х/.159

Эрсдэл бий болсон үед бусдаас тусламж хүсэж хамтран ажиллах арга, тактик эзэмшисэн байх /цэрэг, цагдаа, онцгой байдал бусад орон нутгийн албадтай/ зэрэг сэтгэл зүйн болон бие бялдарын бэлтгэлжилтээрээ бусад харуул хамгаалалтын ажилтнаас ялгарч байх ёстой.